

ТАНИЛЦУУЛГА

“ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн (ӨНТХ) 30 дугаар зүйлийн 30.1.6-д заасан чиг үүргийн дагуу “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ыг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор батлан гаргаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 5059 дугаартайгаар бүртгүүлснээр хүчин төгөлдөр мөрдүүлж эхэлсэн.

“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-д Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 33-р тэмдэглэл, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2022 оны 03/1443 тоот албан бичиг зэрэгт үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тэр дундаа хүүхдийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор нэмэлтээр 30.10.5¹ дахь заалтыг оруулан баталж, Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэсэн.

Энэ удаа тус хөтөлбөрт тавигдах шаардлагад дараах үндэслэл, хууль тогтоомжийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулаад байна. Үүнд:

1. Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн дүгнэлт, зөвлөмж
 - Зөвшөөрлийн харилцаатай холбоотой болон үйлчилгээ эрхлэгчдэд шаардлагагүй захиргааны ачаалал үүсгэж буй зохицуулалтыг хасах;
 - Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулсан хөтөлбөрт шаардлага тавьсан заалт тусгагдсан эсэхийг хянаж, холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох;
2. Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг - хууль тогтоомжийн нийцлийг хангах
 - Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн заалттай давхардсан заалтыг хүчингүй болгох, шаардлагатай тохиолдолд эшлэлээр зохицуулах;
 - Хуулиар зохицуулах шаардлагатай асуудлыг журмаар зохицуулсан, эсхүл хуулиар олгоогүй хориглолт, хязгаарлалт тогтоосон зохицуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэх;
3. ХХЗХ-ны даргын 2023 оны А/182 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж”-ын дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зохицуулалтын нийт баримт бичгүүдэд 2023, 2024 онуудад үе шаттай үнэлгээг хийж, 3 жил тутамд баримт бичгүүдэд үнэлгээг хийх удирдамжийн дагуу “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Радиогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-уудад үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан.

“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-д дараах агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар олон нийтийн санал асуулгад гарган 2026 оны 08 дугаар сарын 3-ны өдрөөс 09 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл 40 хоногийн хугацаатайгаар санал авч байна.

¹ Хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл бичгэн тайлбартай байна.

“ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА”-Д ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 2.4, 3.4, 3.5, 3.6, 3.10.1, 3.10.2, 3.10.5, 3.12, 3.14, 3.15, 3.17, 4.7 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай.

1.1. 2.4 дэх хэсгийг “Өргөн нэвтрүүлгийн телевиз нь үзэгчдийн мэдээлэл, боловсрол, соёлын хэрэгцээг хангах зорилгоор нийгмийн амьдралын олон чиглэлийн агуулга бүхий олон талт хөтөлбөр нэвтрүүлнэ.” гэж,

1.2. 3.4 дэх хэсгийг “Монгол Улс болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй нь, арилжааны телевизийн хувьд 20 хувиас доошгүй нь өөрийн бүтээл, нэвтрүүлэг байх бөгөөд өөрийн редакцын бодлогын хүрээнд тухайн телевизэд бэлтгэсэн байна.” гэж;

1.3. 3.5 дахь хэсгийг “Төлбөртэй болон тодорхой чиглэлээр дагнасан, төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны телевизэд энэхүү шаардлагын 3.4-д заасан хувь хэмжээний шаардлага хамаарахгүй.” гэж;

1.4. 3.6 дахь хэсгийг “Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 25 хувиас доошгүй нь өөрийн болон тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн, мэдээ, мэдээлэл, бүтээл, нэвтрүүлэг байна.” гэж,

1.5. 3.10.1 дэх заалтыг “Жилд 200 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлнэ.” гэж;

1.6. 3.10.2 дахь заалтыг “ Жилд 130 цагаас багагүй хугацааны 6+, 12+ насны ангилалтай (бага, өсвөр насны) хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлнэ.” гэж;

1.7. 3.10.5 дахь заалтыг “Хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл бичгэн тайлбартай байна.” гэж;

1.8. 3.12 дахь хэсгийг “Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх өргөн нэвтрүүлгийн телевиз нь улиралд 60 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэж нэвтрүүлнэ.” гэж;

1.9. 3.14 дэх хэсгийг “Балчир насны буюу 3+ насны ангилалтай хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нь үндэсний бүтээл, нэвтрүүлэг байна.” гэж;

1.10. 3.15 дахь хэсгийг “ Хүүхдэд зориулсан нэвтрүүлэгт үндэсний хүүхэлдэйн киног оруулж тооцно.” гэж

1.11. 3.17 дахь хэсгийг “ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2.4-ийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг,

хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг болон бусад төрлийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 10 хувиас доошгүйг хадмал тайлбартай нэвтрүүлэх үе шаттай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг хагас жил тутамд Зохицуулах хороонд ирүүлнэ.” гэж;

1.12. 4.7 дэх хэсгийг “Өдрийн цагаар буюу 06:00-22:00 цагийн хооронд 18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх ангиллын кино, нэвтрүүлгийг нэвтрүүлэхгүй” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

2. Хөтөлбөрт тавигдах шаардлагын 1.4 дэх хэсэг, 2.5, 2.11 дэх хэсэг, 3.11, 3.12.1, 3.12.2, 3.12.3 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг:

ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗААЛТУУД

№	Хөтөлбөрт тавигдах шаардлагын заалт	Өөрчлөлт оруулах санал	Үндэслэл, тайлбар
	Нэг. Нийтлэг үндэслэл		
1	1.4.Олон нийтийн телевизийн үндсэн болон бусад сувгийн хөтөлбөрт тавигдах шаардлагатай холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулна.	Хүчингүй болгох	ӨНТХ-ийн 3.1-д “Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаа, хөтөлбөрт тавигдах шаардлагатай холбоотой харилцааг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар зохицуулна.” гэж заасан тул давхардсан зохицуулалтыг хүчингүй болгох.
	Хоёр. Үйлчилгээ эрхлэх хүрээ		
2	2.4 Өргөн нэвтрүүлгийн телевиз нь олон талт хөтөлбөртэй байх бөгөөд аль нэг чиглэлээр дагнасан төрөлжсөн хөтөлбөр дамжуулахгүй.	Өөрчлөн найруулах 2.4. Өргөн нэвтрүүлгийн телевиз нь үзэгчдийн мэдээлэл, боловсрол, соёлын хэрэгцээг хангах зорилгоор нийгмийн амьдралын олон чиглэлийн агуулга бүхий олон талт хөтөлбөр нэвтрүүлнэ.	ӨНТХ-ийн 4.1.21-т өргөн нэвтрүүлгийн телевиз нь олон талт хөтөлбөртэй үйлчилгээ байхаар тодорхойлсон бөгөөд хуулийн бусад зүйл, заалтаар хүүхэд, боловсрол, танин мэдэхүй, үндэсний түүх, соёлын нэвтрүүлэг бэлтгэн хүргэх шаардлага тавьсан. Мөн хуулийн 23.5.5, энэхүү шаардлагын 3.10, 3.12 дахь заалтаар эдгээр нэвтрүүлгийн цаг, хугацааг тогтоосон тул өргөн нэвтрүүлгийн телевиз нь олон төрлийн нэвтрүүлэг, хөтөлбөр хүргэх нь зайлшгүй тул аль нэг чиглэлээр дагнасан төрөлжсөн хөтөлбөр дамжуулахгүй гэж хуулиас доогуур түвшний хэм хэмжээний актаар хориглосон агуулга тогтоосныг хассан.
3	2.5 Олон талт хөтөлбөр гэж улс орон, дэлхий дахины цаг үеийн мэдээ, мэдээлэл, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, хүүхэд, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан бүтээл, нэвтрүүлгийн багцыг ойлгоно.	Хүчингүй болгох	Заалт нь “олон талт хөтөлбөр” гэсэн ойлголтыг тайлбарласан нэр томъёоны шинжтэй зохицуулалт бөгөөд хуулиас доогуур түвшний хэм хэмжээний актаар нэр томъёо тодорхойлохыг хууль зүйн техникийн хувьд хориглодог байна.
4	2.11 Гамшгийн болон онцгой байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээлэл, урсдаг болон үгэн хэлбэрийн мэдээг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23.4-д заасан журмын дагуу нэвтрүүлнэ.	Хүчингүй болгох	ӨНТХ-ийн 23.4 дэх хэсэгт гамшгийн болон онцгой байдал, урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журмыг дагаж мөрдөхөөр зохицуулсан тул энэхүү заалт нь хуулийн зохицуулалттай давхардсан агуулгатай.
	Гурав. Бүтээл, нэвтрүүлгийн хувь хэмжээнд тавигдах шаардлага		
	3.4 Телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй нь өөрийн	Өөрчлөн найруулах	Одоогийн хөтөлбөрийн шаардлагаар телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагт эзлэх өөрийн бүтээлийн хувь хэмжээг

5	бүтээл, нэвтрүүлэг байх бөгөөд өөрийн редакцын бодлогын хүрээнд тухайн телевизэд бэлтгэсэн байна.	3.4 Монгол Улс болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй нь, арилжааны телевизийн хувьд 20 хувиас доошгүй нь өөрийн бүтээл, нэвтрүүлэг байх бөгөөд өөрийн редакцын бодлогын хүрээнд тухайн телевизэд бэлтгэсэн байна.	бүх төрлийн телевизийн ангилалд (өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевиз) ижил хувь хэмжээг тогтоосон байдаг. Гэвч өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага өөр хоорондоо ялгаатай (өргөн нэвтрүүлгийн телевиз нь заавал олон талт хөтөлбөртэй байх, үндэсний түүх, соёл уламжлал, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг нэвтрүүлэх зэрэг) байдаг онцлогтой. Бүтээл үйлдвэрлэл, түгээлтийн бүтэц өөрчлөгдөж, студи, продакшн болон бусад контент үйлдвэрлэгчтэй хамтран ажиллах хандлага нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд бүхий л төрлийн телевизэд өөрийн бүтээл, нэвтрүүлгийн хувь хэмжээнд хатуу шаардлага тогтоох нь зах зээлийн бодит нөхцөлтэй нийцэхгүй байгаа бөгөөд цаашлаад контент бүрдүүлэлтийн уян хатан байдлыг хязгаарлах эрсдэлтэй байна. Телевизийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингоор орон нутгийн телевиз болон арилжааны телевизүүдийн (төрөлжсөн бус хөтөлбөртэй) 50 дээш хувь нь заалтын хэрэгжилтийг хангахгүй байдалтай байсаар байна. Мөн нийт телевизийн 30 хувь нь энэхүү шаардлагын тал хувийг буюу ердөө 15 хувийг л хангаж байна. Үүнээс орон нутгийн болон арилжааны телевизийн хөтөлбөрт тавигдах өөрийн бүтээлийн хувь хэмжээг эргэн харах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.
6	3.5 Төлбөртэй болон тодорхой чиглэлээр дагнасан, төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны телевизэд энэхүү шаардлагын 3.4-д заасан хувь хэмжээний шаардлага хамаарахгүй бөгөөд өөрийн редакцын бодлогын хүрээнд бэлтгэсэн тодорхой хэмжээний өөрийн бүтээл, нэвтрүүлэгтэй байна.	Өөрчлөн найруулах 3.5 Төлбөртэй болон тодорхой чиглэлээр дагнасан, төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны телевизэд энэхүү шаардлагын 3.4-д заасан хувь хэмжээний шаардлага хамаарахгүй.	Энэхүү заалтаар төлбөртэй болон төрөлжсөн хөтөлбөртэй арилжааны телевизийн хөтөлбөрт өөрийн бүтээлийн 30 хувийн шаардлага хамаарахгүй гэсэн ч “тодорхой хэмжээний өөрийн бүтээл, нэвтрүүлэгтэй байна” гэсэн нь тодорхой бус нөхцөл байдал үүсгэж байна. Түүнчлэн “тодорхой хэмжээ” гэх ойлголт нь хэмжигдэхүйц шалгуургүй тул хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавихад ялгаатай ойлголт үүсгэдэг. Төлбөртэй болон төрөлжсөн телевиз нь спорт, хүүхэд, дуу хөгжим, кино зэрэг чиглэлээр төрөлжсөн контент түгээдэг онцлогтой. Эдгээр төрөлжсөн хөтөлбөртэй телевиз нь ихэвчлэн студи, продакшн болон бусад гадаад, дотоодыг контент үйлдвэрлэгчдээс оюуны өмчийн эрхийн гэрээний үндсэн дээр хөтөлбөрөө бүрдүүлэн ажиллаж байна. Контент үйлдвэрлэл, түгээлтийн өнөөгийн бүтэц өөрчлөгдөж буй нөхцөлд төрөлжсөн болон төлбөртэй телевизийн үйл ажиллагааны онцлог, редакцын бодлогын уян хатан байдлыг хангах хүрээнд заавал өөрсдөө контент үйлдвэрлэх шаардлагыг хасах нь зүйтэй гэж үзсэн.

7	3.6 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 30 хувиас доошгүй нь тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн, тухайн орон нутагт бүтээсэн мэдээ, мэдээлэл, бүтээл, нэвтрүүлэг байна.	Өөрчлөн найруулах 3.6 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевизийн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 25 хувиас доошгүй нь өөрийн болон тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн, мэдээ, мэдээлэл, бүтээл, нэвтрүүлэг байна.	Мониторингоор хэрэгжилтийг авч үзэхэд орон нутгийн телевизийн өөрийн болон орон нутгийн бүтээл нь давхар тооцогдох нь түгээмэл бөгөөд эдгээр нэвтрүүлгийн хоорондын ялгаа харьцангуй бага байдаг. Орон нутгийн телевизийн бүтээлээс гадна бусдын бүтээсэн тухайн орон нутгийн агуулга, чиглэлийг тусгасан бүтээлийг орон нутгийн бүтээлд хамруулан тооцдог. Иймд “тухайн орон нутагт бүтээсэн” гэж хязгаарлахын оронд тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, бүтээл, нэвтрүүлэг байх зарчмаар зохицуулах нь орон нутгийн телевизийн үйл ажиллагааны бодит нөхцөл, контент үйлдвэрлэлийн өнөөгийн бүтэцтэй илүү нийцнэ гэж үзэж байна. Тиймээс орон нутгийн телевизийн хувьд ӨНТХ-ийн 23.5.2, 23.5.3 дахь заалтыг нь нэгтгэн 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 25 хувиас доошгүй байх гэж өөрчлөхөөр төсөлд тусгав.
8	3.10.1 Жилд 200 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлэх ба нийт цагийн 20 хувиас доошгүй нь шинэ бүтээл байна;	Өөрчлөн найруулах 3.10.1 Жилд 200 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлнэ.	“Шинэ бүтээл” гэх ойлголт нь ӨНТХ-д тусгагдаагүй бөгөөд бусад холбогдох хууль тогтоомжоор үйлчилгээ эрхлэгчид үүрэг болгосон зохицуулалт биш түүнчлэн Патентын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.17 дахь заалтад “шинэ бүтээл” гэсэн нэр томъёог өөр агуулгаар тодорхойлсон байдаг.
9	3.10.2 Жилд 130 цагаас багагүй хугацааны 6+, 12+ насны ангилалтай (бага, өсвөр насны) хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлэх ба нийт цагийн 20 хувиас доошгүй нь шинэ бүтээл байна.	Өөрчлөн найруулах 3.10.2 Жилд 130 цагаас багагүй хугацааны 6+, 12+ насны ангилалтай (бага, өсвөр насны) хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлнэ.	“Шинэ бүтээл” гэх ойлголт нь ӨНТХ-д тусгагдаагүй бөгөөд бусад холбогдох хууль тогтоомжоор үйлчилгээ эрхлэгчид үүрэг болгосон зохицуулалт биш түүнчлэн Патентын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.17 дахь заалтад “шинэ бүтээл” гэсэн нэр томъёог өөр агуулгаар тодорхойлсон байдаг.
10	3.10.5 Энэхүү шаардлагын 3.10.2-т заасан хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл бичгэн тайлбартай байна.	Өөрчлөн найруулах 3.10.5 Хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл бичгэн тайлбартай байна.	Одоогийн зохицуулалт нь зөвхөн 3.10.2-т заасан 6+, 12+ насны ангилалтай хүүхдийн нэвтрүүлэгт хамаарч байгаа бөгөөд практикт 3+ насны ангилалтай хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй, бичгэн тайлбартай хүргэсэн тохиолдолд уг цагийг шаардлагын хэрэгжилтэд тооцох боломжгүй нөхцөл үүсгэж байна. Иймд хүртээмжийн шаардлагыг зөвхөн 6+, 12+ насны ангиллын хүүхдийн нэвтрүүлгээр хязгаарлахгүйгээр хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагт хамааруулан зохицуулснаар үйлчилгээ эрхлэгчид хэрэгжилтийг уян хатан хангах, бүх насны хүүхдийн мэдээлэл авах эрх, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж бүрдэх тул энэ шаардлага нь бүх насны хүүхдийн нэвтрүүлэгт хамаарахаар өөрчлөн найруулах нь зүйтэй.

11	3.11 Шинэ бүтээл гэдэгт тухайн жилд шинээр бүтээсэн нэвтрүүлгийг тухайн телевизээр анх удаа нэвтрүүлснийг ойлгоно.	Хүчингүй болгох	“Шинэ бүтээл” гэх ойлголт нь ӨНТХ-д тусгагдаагүй бөгөөд бусад холбогдох хууль тогтоомжоор үйлчилгээ эрхлэгчид үүрэг болгосон зохицуулалт биш түүнчлэн Патентын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.17 дахь заалтад “шинэ бүтээл” гэсэн нэр томъёог өөр агуулгаар тодорхойлсон байдаг.
12	3.12 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх өргөн нэвтрүүлгийн телевиз нь үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг, хүүхдийн нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлэхдээ дараах шаардлагыг хангана. Үүнд:	Өөрчлөн найруулах Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх өргөн нэвтрүүлгийн телевиз нь улиралд 60 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэж нэвтрүүлнэ.	Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орчин, үйл ажиллагааны онцлог, хүний нөөцийн хүрэлцээгүй байдал, санхүү болон бүтээл үйлдвэрлэлийн бодит нөхцөл боломжийг харгалзан үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд, танин мэдэхүйн чиглэлийн нэвтрүүлгийг төрөл тус бүрээр цагийн шаардлага тогтоохын оронд эдгээр төрлийн нэвтрүүлгийн цагийн нийлбэрээр шаардлагаар тавих байдлаар уян хатан зохицуулах нь зохистой байна.
13	3.12.1 Жилд 180 цагаас багагүй хугацааны үндэсний түүх, соёл, уламжлалын нэвтрүүлэг нэвтрүүлнэ;	Хүчингүй болгох	Энэ нь орон нутгийн телевизийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих, редакцын бодлогоо орон нутгийн хэрэгцээ, онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой тул 3.12 дахь заалтыг бүхэлд нь өөрчлөн найруулж, дэд заалтуудыг хүчингүй болгох.
14	3.12.2 Жилд 150 цагаас багагүй хугацааны хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нэвтрүүлнэ;		
15	3.12.3 Жилд 90 цагаас багагүй хугацааны танин мэдэхүйн нэвтрүүлэг нэвтрүүлнэ.		
16	3.14 Балчир насны буюу 3+ насны ангилалтай хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нь үндэсний бүтээл байх ба нэг нэвтрүүлгийн үргэлжлэх хугацаа 15 минутаас ихгүй байна.	Өөрчлөн найруулах 3.14 Балчир насны буюу 3+ насны ангилалтай хүүхдэд зориулсан нэвтрүүлэг нь үндэсний бүтээл, нэвтрүүлэг байна.	MNS 6587 стандартын 4.2 Балчир насны хүүхдэд тохиромжтой нэвтрүүлэг /3+/. Үүнд 3-5 нас буюу балчир насны хүүхдийн танин мэдэхүйд зориулсан, 15 минутаас хэтрэхгүй үргэлжлэх нэвтрүүлэг хамаарна гэж заасан байдаг тул давхардсан зохицуулалтыг хасах.
17	3.15 Хүүхдэд зориулсан нэвтрүүлэгт хүүхдийн болон хүүхэлдэйн киног оруулж тооцохгүй.	Өөрчлөн найруулах 3.15 Хүүхдэд зориулсан нэвтрүүлэгт үндэсний хүүхэлдэйн киног оруулж тооцно.	Үндэсний бүтээлийг дэмжин хөгжүүлэх зорилгоор дотоодод бүтээгдсэн хүүхдэд зориулсан хүүхэлдэйн кино, аниме хэлбэрийн бүтээлийг хүүхдийн нэвтрүүлгийн цагт оруулж тооцох.

18	3.17 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2.4-ийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг Зохицуулах хороонд ирүүлэх ба хагас жил тутам тайлагнана.	Өөрчлөн найруулах Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2.4-ийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх цаг үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, танин мэдэхүйн нэвтрүүлэг болон бусад төрлийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 10 хувиас доошгүйг хадмал тайлбартай нэвтрүүлэх, цаашид жил бүр нэмэгдүүлэх үе шаттай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Тус төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хугацааны хуваарийг хагас жил тутамд Зохицуулах хороонд ирүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд дохионы хэл, хадмал тайлбартай гаргах нэвтрүүлгийн төрлийг зөвхөн мэдээ, мэдээлэл, хүүхэд, танин мэдэхүйн нэвтрүүлэг гэж хязгаарлахгүйгээр бусад төрлийн контент, нэвтрүүлгийг мөн хүртээмжтэй нэвтрүүлэх зохицуулалтыг тусгасан. ХХЗХ-оос байнгын хяналт, мониторинг хийж байгаа тул үйлчилгээ эрхлэгчдээс дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлсэн тайланг гаргуулах авах шаардлагагүй гэж үзсэн.
Дөрөв. Хөтөлбөрт хүүхэд хамгаалах чиглэлээр тавих шаардлага			
19	4.7 Насанд хүрэгчдэд буюу 18-аас дээш насныханд зориулсан кино, нэвтрүүлгийг 06:00-22:00 цагийн хооронд нэвтрүүлэхгүй.	Өөрчлөн найруулах 4.7 Өдрийн цагаар буюу 06:00-22:00 цагийн хооронд 18 ба түүнээс дээш насныханд зөвшөөрөх ангиллын кино, нэвтрүүлгийг нэвтрүүлэхгүй.	Кино урлагийг дэмжих тухай хуулийн” 21.2-д заасантай нийцүүлэн өөрчлөн найруулав.



ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ
ЯВЦАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын нэмэлт/

№	Аргачлал	Асуудал	Дэлгэрэнгүй тайлбар /судалгаа байгаа бол хавсаргах/
1	акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох	Хуулиар тусгайлан эрх олгогдсон байх	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ыг Харилцаа холбооны зохицуулах хороонд батлах эрх олгогдсон.
2		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтоох	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтын дагуу “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулснаар Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасан захиргааны хэм хэмжээний актын нийцлийг хангах, зохицуулалтын хэрэгжилтийн үнэлгээ болон бодит хэрэгжилтийн үр дүнд тулгуурлан хэрэгжилтэд хүндрэл учруулж буй зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль тогтоомжтой давхардсан болон нийцээгүй зохицуулалтыг цэгцлэх, орон нутгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн мөрдөх шаардлагыг бодит нөхцөлд нийцүүлэн илүү хэрэгжих боломжтой болгох, хүүхэд хамгаалалтай холбоотой зохицуулалтын хэрэгжилт болон хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгыг хангах юм.
3		Зорилт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 21, 23 дугаар зүйл бүхэлдээ, 27 дугаар зүйлийн зарим хэсэгт заасан чиг үүрэг Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн.
4	тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Актаар зохицуулах харилцааны хүрээ, хэмжээг тодорхой заах	“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын зохицуулах харилцааны хүрээ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалтуудаар тодорхойлсон телевизийн үйлчилгээний төрөл буюу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.7, 9.14-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үйлчилнэ.
5		Бүтцийн хувьд гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг, шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох тухай хэсэг болон акт хүчин төгөлдөр болох хугацааг заах	“Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага” нь Зохицуулах хорооны хуралдааны 2021 оны 01 тоот тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5059 дугаарт бүртгэгдснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Журам оруулах энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтийг 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний акт нь энэ хуулийн зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж,” гэж заасныг үндэслэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.
6		Бүтцийн хувьд хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй байхыг заах	Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа журам нь бүтцийн хувьд 5 зүйл, 47 хэсэг, 7 заалттай. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар баримт бичиг нь 5 зүйл, 43 хэсэг, 4 заалттай болно.

7	акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох		Журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар телевизийн үйлчилгээ эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөхгүй. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн одоогийн тусгай зөвшөөрөл, эрхлэх үйл ажиллагаанд өөрчлөлт орохгүй. Уг баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны www.crc.gov.mn цахим хуудсаар 2026 оны 07 дугаар сарын 31-нээс 09 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл 40 хоногийн хугацаатайгаар санал авахаар байршуулсан. Мөн нийт телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам болон бусад холбогдох төрийн байгууллага, Монголын телевизүүдийн холбоо, Монголын арилжааны телевизүүдийн Дуун холбоо, Монголын олон суваг дамжуулагчийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн Гал хөгжил холбоо зэрэг салбарын мэргэжлийн холбоодоос санал авахаар хүргүүлэв. Төсөлд холбогдох байгууллагууд, үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн саналыг авч тусган ХХЗХ-ны Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, Хорооны 10 дугаар сарын ээлжит хуралдаанаар хэлэлцэж, батална.
8	хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх	Хүний эрх, эрх чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй
9		Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Үгүй
10		Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм
11		Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй
12		Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Үгүй
13		Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх	Үгүй
14		Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх	Үгүй
15		Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх	Үгүй
16		Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй

17		Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй
18		Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх, байгаа бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
19	тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт гаргах эсэх	Эрх зүйн зохицуулалтын давхардал үүссэн эсэх	Үүсээгүй
20		Шинээр төрийн байгууллага байгуулах эсэх	Үгүй
21		Төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх эсэх	Үгүй
22	актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоог хийх	Захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй
23		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зардал үүсэх, эсхүл зардал бууруулах эсэх	Үгүй

ХЯНАСАН

Э.ЗОЛБАЯР /ӨНЗГ-ын дарга/

Б.МЯГМАРДОРЖ /Хуулийн хэлтсийн дарга/

БОЛОВСРУУЛСАН

Б.АЛТАЙ /ӨНЗГ-ын ӨНЗБТХ-ийн ахлах мэргэжилтэн/

Г.ГАНЧИМЭГ /ӨНЗГ-ын ӨНЗБТХ-ийн мэргэжилтэн/